

## 13

## ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ШИНЭЧЛЭЛ

## Д. Намжил

Төрийн бус Удирдлага Санхүүжилтийн тухай хууль УИХ-аар батлагдан 2003 оны нэгдүгээр сараас хэрэгжиж эхэллээ. Энэ хууль төр, засгийн хэмжээнд ойрын болон дунд хугацааны санхүү-мөнгөний бодлого тодорхойлох тулгуур баримт бичиг болон үйлчилж эхэллээ гэсэн үг.

Санхүү-мөнгөний бодлогын хүрээнд энэ хуулийн заалтыг баримтлан улсын болон орон нутгийн төсөв хоорондын харилцааг шинэчлэх арга хэмжээг 2003, 2004 оны төсвийн төлөвлөгөөг боловсруулахдаа авч хэрэгжүүлж байна. Энэ арга хэмжээ нь улсын төсвөөс орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ хөгжингүй орнуудад /Австрали, Шинэ Зеланд/ хэрэглэгдэж буй шилжүүлгийн арга, зарчимд үндэслэгдсэн болно. Шилжүүлгийн аргын гол зарчим нь дээд шатны төсвөөс хөрөнгийн дутагдалтай бүс нутаг буюу орон нутгийн төсөвт хүн амын тоо, нэг хүн амд оногдох хэрэглээний дундаж түвшинг үндэслэн хөрөнгийн шилжүүлэг хийхэд чиглэгдсэн болно. 2003 оны төсвийн төлөвлөлтөөс эхлэн хэрэгжүүлж буй шилжүүлгийн арга нь бүс нутгийн хүрээнд хүн амын хөгжлийг хангах тэдний хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой хэрэгжүүлж эхэлсэн санхүүжилтийн дэвшилтэт арга хэрэгсэл юм.

Улсын төсвөөс хөрөнгийн дутагдалтай аймагт шилжүүлэг хийхэд улсын төсөвт бүрэн дайчлагдаж буй НӨТ-ын эх үүсвэрийг ашиглаж байна.

Орон нутгийн төсвийн тэтгэврийг хангах, бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор улсын төсвөөс шилжүүлгийн аргаар хуваарилагдах хөрөнгө нэмэгдэх хандлагатай байна.

Үзүүлэлт		2003	2004
1	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжүүлсэн НӨТ /тэрбум төг/	7,2	11,7
2	Буцаан шилжүүлсэн НӨТ-ын хэмжээ /хувиар/	29	30

Байгаль, цаг уур, өмч хувьчлалын явцаас шалтгаалан Булган, Дорноговь, Төв, Ховд, Дархан-Уул, Говь-сүмбэр аймгийн төсвийн орлого бүрдүүлэлтийн хэмжээ өмнөх оны түвшингээс буурах болжээ. Өөрийн бие даасан байдлаа хадгалж орлого, зарлагын хувьд авч үзвэл орлогын илүүдэлтэй аймаг, нийслэлийн төсвөөс улсын төсөвт хөрөнгө шилжүүлэхдээ

1. Үйл ажиллагааны төлөвлөгөө
2. Бүтээгдэхүүний ангийг харгалзан үзэх болно.

Улсын хэмжээнд Дорноговь, Дархан-Уул, Орхон, нийслэл нь /УБ хот/ бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрийн мэдэлд төвлөрүүлэн орлогоор бүрэн санхүүжүүлэх бол 17 аймаг нь бүтээгдэхүүн, үйлчилгээт арга хэмжээнд улсын төсвөөс 8,5 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг зөвхөн 2004 онд авахаар төлөвлөөд байна.

Орон нутгийн өөрийн орлогоор нийт санхүүжилтийг бүрэн нөхөж буй нийслэл, Орхон, Дархан-Уул, Дорноговь аймаг 2004 онд 1618 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт тэгшитгэлийн журмаар оруулах тооцоотой байна.

Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ, бүтэц

Хот		2004 /дүнд эзлэх хувь/
1	Улаанбаатар	58,8
2	Дорноговь	1,0
3	Орхон	37,8
4	Дархан-Уул	2,3
5	Нийт дүн	100

Орон нутгийн төсөв боловсруулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах гол цөм нь ТБУСанхүүжилтийн хуулиар бүтээгдэхүүн, үр дүнг зөв тодорхойлох замаар санхүүжилт хийх явдал гэж үзэж байна.

Засгийн Газрын 2003 оны 203-р тогтоолоор бүтээгдэхүүний анги тус бүрээр төсөв боловсруулахад өртгийн бүтцийг оновчтой тодорхойлох түүнийг хямдруулах, үр дүнтэй уялдуулахад ТЭЗахирагчийн анхааралыг хандуулах зорилго тавигдаж болно.

Төр, орон нутгийн хэмжээнд өөрөө удирдах байгууллагын төсөв бүрдүүлэлт, хуваарилалт нь өмч хувьчлалын нөхцөл байдалтай салшгүй холбоотой юм. Томоохон аж ахуйн нэгжийн өмч хувьчлалын дараах байдлаас үзэхэд Эрдэнэт, АПУ, НИК, Худалдаа Хөгжлийн банк, ХААН банкнаас төсөвт оруулах орлогын хэмжээ буурч байгаа нь эдгээр аж ахуйн нэгжийн төсөвтэй харилцах харилцаанд гарч буй өнөөгийн нэг онцлог гэж хэлж болно. Энэ нь нэг талаас төр, орон нутгийн хэмжээнд төсвийн орлого бүрдүүлэлтэнд ихээхэн өөрчлөлт гарч, орон нутагт хүн ам, хэрэглээгээр дамжин төсөвт орох орлого нэмэгдэж, үндсэн ачаалал хэрэглэгч рүү шилжих үйл явц явагдах болов.

Нийт улсын хэмжээнд авч үзвэл орон нутгийн төсөв бүрдүүлэлтэнд ноцтой нөлөөлсөн нэг хүчин зүйл нь сүүлийн 3 жилд нийт 10 сая мал хорогдсон нь хөдөө нутагт малчин өрхийн орлого эрс буурах, ядуурал, ажилгүйдэл нэмэгдэх, хот руу чиглэсэн их нүүдэл, төвлөрөл үүсэх шалтгаан болжээ.

Засгийн Газар ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хэд хэдэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлж байгаа нь бүс нутгийн хөгжлийг хангах, хүн амын төвлөрлийг сааруулах ач холбогдолтой.

Үүнд:

1. Мянганы зам
2. Эрчим хүчний нэгдсэн сүлжээ байгуулах
3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
4. Бүс нутагт бөөний худалдааны сүлжээ байгуулах

УИХ-аас Засгийн Газрын боловсруулсан бүс, бүсүүдийн тулгуур төвүүдийг батлан гаргаж,

1. Баруун бүс – Ховд, Улиастай
2. Хангайн бүс – Хархорин, Эрдэнэт
3. Төвийн бүс – Зуунмод, Дархан-Уул
4. Зүүн бүс – Чойбалсан, Өндөрхаан
5. Говийн бүс – Сайншанд, Замын-Үүд байхаар тогтоон тус тус мөрдөж эхлээд байна.

Монгол орны дунд, урт хугацааны хөгжлийн тулгуур үндэс нь эдгээр бүс нутаг, бүсийн тулгуур төв дээр үндэслэх нь зайлшгүй болоод байна. Иймд бүс нутгийн хөгжлийг Засгийн Газрын ойрын болон дунд хугацааны хөтөлбөртэй /зорилттой/ уялдуулан хэд хэдэн парамагтик асуудалд анхаарал хандуулах нь эцсийн дүнд нийгмийн гишүүд, өрх гэрийн амьдралын түвшинг тогтвортой дээшлүүлэх болно. Үүний тулд:

Нэгдүгээрт. Бүс нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа улс төрийн тогтолцоонд өөрчлөлт оруулах замаар аймаг, сум, хот, тосгон хоорондын үйлдвэрлэл, нийгмийн болон дэд бүтцийн уялдааг онцгойрон анхаарах хэрэгтэй.

Хоёрдугаарт. Бүс нутгийн захирагч, түүний төсөв бүрдүүлэлт, хуваарилалтын эрх зүйн статусыг тодорхой болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх нь зүйтэй.

Гуравдугаарт. Бүс нутгийн дунд, урт хугацааны ерөнхий төлөвлөгөөг бүс нутаг тус бүрээр боловсруулах ажлыг төсөв, хөрөнгөтэй уялдуулахын тулд салбарын хүрээнд /ТЭЗ/ төсөв баталж байгаа журмыг бүс нутгийн /Захирагч/ хэмжээнд төсөв батлах үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээг авч явуулах

Дөрөвдүгээрт. Бүс нутаг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хүн ам, малчин өрх тухайн бүс нутаг дотроо чөлөөтэй шилжин суурших нөхцлийг хангах

Тавдугаарт. УИХ-аас баталсан “Чөлөөт бүс”-ийн тухай, 2003 онд баталсан “Үйлдвэрлэл технологийн парк байгуулах” тухай үндсэн чиглэл тус бүрийг бүс нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах

Зургаадугаарт. Засгийн Газраас хоршооны хөгжлийг дэмжих, хоршооны эрх зүй, бизнес удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг бүс нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулахад анхаарал хандуулах хэрэгтэй. Засгийн Газраас бүс нутгийн хүрээнд хоршооллыг хөгжүүлэх, бизнесийн болон эрх зүйн нааштай орчин бүрдүүлэхэд тулгуур төв, усалгаатай тариалангийн үйлдвэрийн хөтөлбөрийг хандивлагч улс, Олон Улсын байгууллага, ОХУ, Хятад

Улсын Засгийн Газрын зээл тусламжийн эх үүсвэрийг ашиглан нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Долдугаарт. Засгийн Газрын бодлогын хүрээнд Монгол банк болон арилжааны банкуудын актив хөрөнгө, чөлөөт үлдэгдлийг бүс нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлэн бүс нутагт хөрөнгө, санхүүгийн төвлөрөл бий болгох зорилгоор бүс нутаг хөгжүүлэх, банк санхүүгийн байгууллага бий болгох нь зүйтэй. Эдгээр арга хэмжээтэй уялдуулан бүс нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан одоогийн сумдын бүтцийг шинээр тогтоох, өөрчлөх шаардлага зайлшгүй гарч байна.